



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/92/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2020 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч
Э.Энхцэцэг

Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetsteg.e@audit.gov.mn

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70503020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

2020.02.27 № 1-6/116
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


1. Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь 2019 онд тээвэр шатахууны зардалд 24.2 сая төгрөг, түлш халаалалтын зардалд 10.6 сая төгрөг, үндсэн хөрөнгө худалдаж авахад 12.8 сая төгрөгийг зарцуулж, шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны зарчим, Засгийн газрын "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 2017 оны 68 дугаар тогтоолыг зөрчсөн байна.
2. Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Си Өү Эй Эл ХХК-аас нийт 62.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, зарцуулсан байна. Энэ нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив тусламж авч болно", 25.5-д "... хандив тусламж өгсөн этгээд төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх, байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.АРИУНАА



2.1. Оршил

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Цэцэгсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 18-аас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06/23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд оновчтой бодлого зохицуулалтаар хангах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх” гэж тусгасан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 547266.5 мянган төгрөгөөс тооцон 547267 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 7206.5 мянган төгрөгөөр тооцсон нь аудитын төлөвлөлтийн үе шатанд 1 хувиар тооцсоныг өөрчлөөгүй холбоотой болно. /шалтгааныг бичих/

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 233623.6 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	2800.6	2800.6
Авлага	1,871.3	177.9	(1,693.4)
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	64,393.6	78,557.6	14,164.0
Үндсэн хөрөнгө	1,645,930.8	2,069,856.4	423,925.6
Нийт хөрөнгө	1,712,195.7	2,151,389.3	439,193.6
Өр төлбөр	14,046.4	0.09	(14,046.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,698,149.3	2,151,389.2	453,239.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,712,195.7	2,151,389.3	439,193.6

Мөнгөн хөрөнгө тайлант оны эцэст 2800.6 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь ахмадын сангийн үлдэгдэл тайлагнагдсан байна.

Авлага буурсан нь 2008 онд үүссэн 1346.2 мянган төгрөгийн авлагыг холбогдох хүн нас барсан шалтгаанаар хассан байна. Энэ авлага нь шүүхийн шийдвэрээр үүссэн авлага ба шийдвэрийг 2009 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Замын-Үүд сумын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэгт хүргүүлсэн гэх боловч тус хэсгээс энэ асуудалтай холбоотой баримт бичиг байхгүй гэсэн хариуг өгсөн байна. Мөн аймгийн ШШГГ-ын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/194 тоот албан бичигт 2008 оны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил өнгөрсөн тохиолдолд ажиллагаа үүсгэх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн байна. Мөн авлагын эхний үлдэгдлийн 525.0 мянган төгрөг нь 2018 оны нэмэлт санхүүжилтийн данснаас буцаан төвлөрүүлсэн шилжүүлгийг авлагаар тусган буцаан авч зарцуулсан байна.

Өглөг буурсан нь 2020 оны 2 ширхэг гүний худгийг тус байгууллагын данс хооронд шилжүүлэн тооцох өглөг байсан ба өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, бүртгэлээс хасах шийдвэрийг үндэслэн 14000.0 мянган төгрөгийн өр төлбөрийг хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 98919.3 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 84758.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан эцсийн үлдэгдлээс гадна сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3712.5 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө нь дүн өссөн нь аймгийн ЗДТГ-аас багийн Засаг дарга нарт 2100.0 мянган төгрөгийн 2 ширхэг мотоцикл, Улсын Их Хурлын гишүүнээс 30500.0 мянган төгрөгийн автомашин, Дорноговь их хөгжил сангаас 160000.0 мянган төгрөгийн наадмын талбай, 145000.0 мянган төгрөгийн төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барьсан, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 192908.5 мянган төгрөгийн өртөг бүхий ТАХ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 20000.0 мянган төгрөгийн камержуулалтын ажил хийгдсэн, төсвийн хөрөнгөөр 23610.7 мянган төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасантай холбоотой байна. Мөн сумын ИТХ-ын 2019 оны 02/23 тоот тогтоолоор 44276.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын тайлант онд туслах үйл ажиллагааны орлогоор 5000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6177.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 11.8 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5000.0	6177.7	1177.7	123.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих	397235.4	397126.4	-	100
Нийт дүн	402235.4	403304.1	1177.7	111.8

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 402235.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 402235.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 401824.7 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг төлөвлөсний дагуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 155500.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна. Үүнд: Аймгийн ЗДТГ-аас “Тэргүүний сум”-аар шалгарсны шагналын 1500.0 мянган төгрөгийг сумдын төсөвт газруудыг шагнахад, ОБГ-аас шилжүүлсэн 62308.9 мянган төгрөгийг малын шүлхий өвчний зардалд, Статистикийн хэлтсээс шилжүүлсэн 1345.9 мянган төгрөгийг хагас жилийн мал тооллого, өвч тэжээлийн зардалд, ХААГ-аас шилжүүлсэн 300.0 мянган төгрөгийг ХАБ-ийн гишүүдэд олгосон, аймгийн Засаг даргаас 15000.0 сая төгрөгийн дэмжлэгийг сумын ойн бичлэг хийх зардалд, тендерийн баримт бичгийн 397.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд тус тус зарцуулсан байна. Мөн 2019 онд Си Өү Эй Эл ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээний дагуу 62500.0 мянган төгрөгийн санхүүгийн туслалцаа авсан байна. Үүний 9950.0 мянган төгрөгийн малын шүлхий өвчний зардалд, 12280.0 мянган төгрөгийн ботгоны урамшуулалд, 1280.0 мянган төгрөгийг ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд, 1213.0 мянган төгрөгийг сар шинийн нийтийн золголтод тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 116868.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж, 1 албан шаардлагыг тогтоолоо.

2.11.1 Балансын данстай холбоотой асуудал:

Тайлант онд тус байгууллагын бараа материалын данс дахь 26290.2 мянган төгрөгийн мал амьтныг нас дэвшүүлэн бүртгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд аж

ахуйн бүх ажил гүйлгээ, хөрөнгө оруулалт, авлага, бүх өр төлбөр, аж ахуйн ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, бүх орлого, бүх зардал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг арилгах тухай албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 төрлийн мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг хугацаа хоцроож, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 6 шийдвэр мэдээлээгүй, 6 шийдвэр хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15395.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 400000.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгах тухай албан шаардлага тогтоосон байна. Зөвлөмжийн хэрэгжилт болон албан шаардлагын хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аудитаар 2019 оны жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын баримтыг шалгахад тооллого хийсэн эсэхийг нотлох боломжгүй, баримт бүрдэл хангалтгүй байна. Учир нь тооллогын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон ч тооллогыг хугацаанд хэрхэн тоолсон, ямар шийдвэр гарсан, хөрөнгө дутагдсан болон тохирсон эсэх, хурлаар асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн зэргийг нотлох боломжгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”-ыг зөрчиж байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг дутагдах эрсдэлийг бий болгож.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягт нөхөх заавар”-ын 2.8-д заасны дагуу ажлыг зохион байгуулж, холбогдох маягтыг хөтлөн баталгаажуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тооллогыг хийсэн боловч тодорхой шалтгааны улмаас холбогдох маягтыг хөтлөөгүй, баримт бүрдүүлээгүй.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хатанбулаг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар Си Өү Эй Эл ХХК-аас нийт 62500.0 мянган төгрөгийн санхүүгийн туслалцаа авч үйл ажиллагаанд зарцуулах, өр төлбөр шилжүүлэх зэрэг зардалд зарцуулсан байна. Энэ нь НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 25.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага хандив тусламж авч болно”, 25.5-д “... хандив тусламж өгсөн этгээд төсвийн байгууллагын хэрэгцээнд өөрийн барааг худалдах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлдэг байх, байгууллагын ажилтны энэ хуулийн 25.4.2-т зааснаас бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Нутгийн өөрөө удирдах байгууллагын хараат бус байдал хөндөгдөх, ашиг сонирхлыг зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Монгол Улсын НАНБХАСЗАСЗУСТ хуулийн 17 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хандив авахтай холбогдсон хязгаарлалт, холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах.

3. Зардлын холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тайлант онд тус байгууллага тээвэр шатахууны зардалд 24185.5 мянган төгрөг, түлш халаалтын зардалд /нүүрс/ 10574.0 мянган төгрөг, зөөврийн компьютер худалдан авахад 12800.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Эдгээр зардлууд үнийн дүнгээр худалдан авах ажиллагааны харьцуулалтын аргаар тендер зохион байгуулах байтал шууд гэрээ байгуулан, шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Монгол Улсын ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авахад ашиг сонирхол үүсэх, бусад этгээдэд давуу байдал үүсгэх эрсдэлтэй байна.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг авахдаа Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан босго үнийг баримтлан, ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу тендер зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГ ДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,264,845.99	81,532,884.68
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	2,800,367.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	2,800,367.00
3121	Төгрөг	0.00	2,800,367.00
31211	Төрийн сангийн харилцах	-	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	2,800,367.00
33	АВЛАГА	1,871,269.13	177,900.82
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,346,209.00	-
335	Бусад авлага	525,060.13	177,900.82
3351	Байгууллагаас авах авлага	525,060.13	177,900.82
35	БАРАА МАТЕРИАЛ	64,393,576.86	78,554,616.86
351	Түүхий эд материал	22,903,060.12	34,403,060.12
35110	Тусгай зориулалттай материал	22,903,060.12	34,403,060.12
354	Хангамжийн материал	15,200,316.74	17,861,356.74
35410	Бичиг хэргийн материал	5,046,420.00	4,933,440.00
35420	Аж ахуйн материал	1,250,095.00	1,216,815.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,747,300.00	5,965,100.00
35440	Түлш шатах тослох материал	4,156,501.74	5,746,001.74
35600	Мал, амьтад	26,290,200.00	26,290,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,645,930,849.44	2,069,856,416.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,645,930,849.44	2,069,856,416.92
392	Биет хөрөнгө	1,498,930,182.72	1,922,972,416.92
39201	Барилга, байгууламж	767,497,168.70	1,110,705,444.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(15,598,936.24)	(32,748,067.27)
39203	Авто тээврийн хэрэгсэл	199,100,906.00	217,873,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(114,786,850.76)	(123,842,220.77)
39205	Машин, тоног төхөөрөмж	113,685,938.12	129,849,722.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,246,856.04)	(63,588,635.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,464,485.26	44,753,645.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,630,790.59)	(28,046,382.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,403,632,353.30	1,596,540,853.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	(808,132,235.03)	(939,470,742.84)
39217	Номын фонд	10,945,000.00	10,945,000.00
393	Биет бус хөрөнгө	147,000,666.72	146,884,000.00
39301	Програм хангамж	1,784,000.00	1,784,000.00
39302	Хасагдуулга	(1,667,333.28)	(1,784,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	146,884,000.00	146,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,712,195,695.43	2,151,389,301.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	14,046,350.00	90.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,046,350.00	90.00
413	Өглөг	14,046,350.00	90.00
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	(0.00)
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	(0.00)	-
4136	Бусад өглөг	14,046,350.00	90.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,046,350.00	0.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	(0.00)	90.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,698,149,345.43	2,151,389,211.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,698,149,345.43	2,151,389,211.60
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,514,989,636.59	1,514,989,636.59
51101	Өмч: -Төрийн өмч	1,514,989,636.59	1,514,989,636.59
512	Хуримтлагдсан үр дүн	15,867,754.76	469,352,795.86
51210	Өмнөх үеийн үр дүн	15,867,754.76	28,766,720.69
51220	Тайлант үеийн үр дүн	-	440,586,075.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,291,954.08	167,046,779.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,712,195,695.43	2,151,389,301.60

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	837,495,514.02	1,161,231,094.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	389,372,503.92	602,898,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	389,372,503.92	602,898,700.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	388,494,253.92	602,898,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,991,400.01	6,177,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	382,502,853.91	596,721,000.00
120009	Бусад орлого	878,250.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	448,123,010.10	558,332,394.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	109,934,210.10	161,096,994.70
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	109,684,210.10	16,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,000.00	144,596,994.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,188,800.00	397,235,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,188,800.00	397,235,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	636,094,044.96	714,402,541.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	630,511,519.96	708,984,100.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,511,519.96	708,984,100.54
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	214,335,060.00	232,191,674.30
210101	Цалин	214,335,060.00	232,191,674.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,950,196.00	29,939,020.61
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,317,469.00	20,399,062.42
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,161,106.00	2,390,313.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,728,893.00	1,904,573.50
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	431,153.00	476,142.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,311,575.00	4,768,929.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,097,010.00	13,520,902.98
210301	Гэрэл цахилгааны зардал	1,304,860.00	2,200,457.98
210302	Түлш, халаалтын зардал	10,792,150.00	11,320,445.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,916,727.00	43,427,455.00
210401	Бичиг хэргийн материал	3,128,060.00	5,851,580.00
210402	Тээвэр, шатахууны зардал	29,852,277.00	30,181,255.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	11,500,290.00	6,536,440.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	120,000.00	120,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	316,100.00	738,180.00
2105	Нормативт зардал	600,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,985,500.00	6,212,300.00
210604	Урсгал засвар	7,985,500.00	6,212,300.00
2107	Томилолт, зочны зардал	4,271,000.00	4,905,400.00
210702	Дотоод томилолтын зардал	4,271,000.00	4,905,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	29,787,606.00	145,880,418.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,991,045.00	144,363,533.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	312,579.00	552,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,020.00	269,907.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	227,000.00	200,178.00
210807	Газрын төлбөр	13,962.00	278,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	290,568,420.96	232,906,929.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,278,640.00	45,713,774.70
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	742,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,289,780.96	186,451,154.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,582,525.00	5,418,441.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,116,800.00	3,830,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,206,800.00	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,100,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	630,000.00	1,530,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	180,000.00	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	465,725.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	465,725.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,588,441.42
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,588,441.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	201,401,469.06	446,828,552.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	250,293,491.14	6,242,477.57

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	217,073,042.29	6,242,477.57
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	33,220,448.85	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(250,293,491.14)	(6,242,477.57)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(48,892,022.08)	440,586,075.17

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	458,978,987.13	565,039,154.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,869,650.00	6,177,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,869,650.00	6,177,700.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,991,400.00	6,177,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,991,400.00	6,177,700.00
120009	Бусад орлого	878,250.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	452,109,337.13	558,861,454.83
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,920,537.13	161,626,054.83
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	113,670,537.13	16,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	250,000.00	145,126,054.83
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	338,188,800.00	397,235,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	338,188,800.00	397,235,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	449,670,987.13	538,628,087.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	449,670,987.13	538,628,087.83
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	444,373,402.00	533,091,518.28
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	215,194,471.00	232,248,399.40
210101	Үндсэн цалин	215,194,471.00	232,248,399.40
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	26,896,303.00	29,825,517.20
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,717,000.00	20,251,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,214,700.00	2,376,148.50
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,762,603.00	1,929,500.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	442,900.00	469,068.70
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,759,100.00	4,799,400.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	11,334,860.00	12,774,957.98
210301	Гэрэл цахилгааны зардал	1,304,860.00	2,200,457.98
210302	Түлш, халаалтын зардал	10,030,000.00	10,574,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,813,217.00	46,328,840.00
210401	Бичиг хэрэг	4,011,120.00	5,459,200.00
210402	Тээвэр, шатахуун	29,120,927.00	30,993,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,561,590.00	8,536,440.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,580.00	1,220,000.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,139,990.00	9,699,100.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	360,000.00
210604	Урсгал засвар	8,139,990.00	9,339,100.00
2107	Томилолт, зочны зардал	4,271,000.00	4,905,400.00
210702	Дотоод албан томилолт	4,271,000.00	4,905,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,673,561.00	157,080,529.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	31,877,000.00	155,563,644.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	312,579.00	532,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,020.00	289,907.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,000.00	200,178.00
210807	Газрын төлбөр	13,962.00	278,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	99,250,000.00	39,428,774.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,250,000.00	37,928,774.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,500,000.00

Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,297,585.13	5,536,569.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,306,800.00	3,830,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,206,800.00	-
213203	Нийгмийн хамгааллын тэтгэвэр тэтгэмж	2,100,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,530,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	990,785.13	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	990,785.13	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,706,569.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,706,569.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,308,000.00	26,411,067.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,308,000.00	23,610,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,308,000.00	23,610,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,308,000.00	23,610,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,308,000.00	23,610,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,308,000.00)	(23,610,700.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,800,367.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,800,367.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,368,105,636.59	140,237,307.59	76,070,698.10	1,584,413,642.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,310,921.26)	(11,310,921.26)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,368,105,636.59	140,237,307.59	64,759,776.84	1,573,102,721.02
C04	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
C05	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	146,884,000.00	-	(48,892,022.08)	97,991,977.92
C08	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,514,989,636.59	167,291,954.08	15,867,754.76	1,698,149,345.43
D01	2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,514,989,636.59	167,291,954.08	15,867,754.76	1,698,149,345.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	12,898,965.93	12,898,965.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,514,989,636.59	167,291,954.08	28,766,720.69	1,711,048,311.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(245,174.93)	-	(245,174.93)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	440,586,075.17	440,586,075.17
D09	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,514,989,636.59	167,046,779.15	469,352,795.86	2,151,389,211.60

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,235,400.00	403,413,100.00	(1,177,700.00)	100.29
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	402,235,400.00	403,413,100.00	(1,177,700.00)	100.29
210	Бараа, үйлчилгээний зардал	401,435,400.00	401,024,658.58	410,741.42	99.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,461,200.00	232,248,399.40	212,800.60	99.91
210101	Үндсэн цалин	232,461,200.00	232,248,399.40	212,800.60	99.91
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,855,100.00	29,825,517.20	29,582.80	99.90
210201	Тэтгэврийн даатгал	20,251,400.00	20,251,400.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,394,200.00	2,376,148.50	18,051.50	99.25
210203	ҮОМШӨ ний даатгал	1,929,500.00	1,929,500.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	480,600.00	469,068.70	11,531.30	97.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,799,400.00	4,799,400.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,802,000.00	12,774,957.98	27,042.02	99.79
210301	Гэрэл цахилгаан	2,202,000.00	2,200,457.98	1,542.02	99.93
210302	Түлш, халаалт	10,600,000.00	10,574,500.00	25,500.00	99.76
2104	Хангамж, бараа материалын зардал	39,408,400.00	39,404,140.00	4,260.00	99.99
210401	Бичиг хэрэг	5,062,900.00	5,062,200.00	700.00	99.99
210402	Тээвэр (шатахуун)	24,185,500.00	24,185,500.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	8,540,000.00	8,536,440.00	3,560.00	99.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	31,589,100.00	31,579,800.00	9,300.00	99.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,250,000.00	22,240,700.00	9,300.00	99.96
210604	Урсгал засвар	9,339,100.00	9,339,100.00	-	100.00
2107	Томиллолт, зочны зардал	4,907,300.00	4,905,400.00	1,900.00	99.96
210702	Дотоод албан томиллолт	4,907,300.00	4,905,400.00	1,900.00	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	43,112,300.00	42,986,444.00	125,856.00	99.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,487,500.00	41,469,559.00	17,941.00	99.96
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	216,000.00	216,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	532,800.00	532,800.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	380,000.00	289,907.00	90,093.00	76.29
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	218,000.00	200,178.00	17,822.00	91.82
210807	Газрын төлбөр	278,000.00	278,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00	6,500,000.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000.00	1,500,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	800,000.00	800,000.00	-	100.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,588,441.42	(1,588,441.42)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,588,441.42	(1,588,441.42)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	402,235,400.00	403,413,100.00	(1,177,700.00)	100.29
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	397,235,400.00	397,235,400.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	397,235,400.00	397,235,400.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	6,177,700.00	(1,177,700.00)	123.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	6,177,700.00	(1,177,700.00)	123.55
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	158,825,687.83	(158,825,687.83)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	158,825,687.83	(158,825,687.83)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	155,677,559.70	(155,677,559.70)	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	7,204,700.00	(7,204,700.00)	-
210401	Бичиг хэрэг	-	397,000.00	(397,000.00)	-
210402	Тээвэр (шатахуун)	-	6,807,700.00	(6,807,700.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	115,544,085.00	(115,544,085.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	115,544,085.00	(115,544,085.00)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	32,928,774.70	(32,928,774.70)	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	32,928,774.70	(32,928,774.70)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,148,128.13	(3,148,128.13)	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,030,000.00	(3,030,000.00)	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,530,000.00	(1,530,000.00)	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	1,500,000.00	(1,500,000.00)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	118,128.13	(118,128.13)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	118,128.13	(118,128.13)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	161,626,054.83	(161,626,054.83)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	161,626,054.83	(161,626,054.83)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	16,500,000.00	(16,500,000.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	145,126,054.83	(145,126,054.83)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,800,367.00	(2,800,367.00)	-